



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020. 08. 13 № 547

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДОРНОД АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН
ТҮМТИЙН ДАРГА Ж.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн орон нутгийн хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын хувьсгалт нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын хувьсгалт намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“Хэрлэн сумын Монгол ардын хувьсгалт нам”- ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Хэрлэн сумын Монгол ардын хувьсгалт нам”- ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд
Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР БОЛОРТУУЛ



МАХН-ЫН ХЭРЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

ИРГЭДЭЭР ОВОГЛОСОН, ИРГЭДИЙН ТӨЛӨӨ ХӨТӨЛБӨР



Зорилго

МАХН нь Хэрлэн сумын иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй хотод амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

- Монгол хүн бүр эрүүл аюулгүй хотод амьдрах эрхийг дээдлэж Өрх бүрт орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.
- Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрт шаардлагатай дэмжлэгийг үзүүлж боловсролд тэгш хамруулна.
- Эхний ээлжинд эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтлана.
- Зээлийн хүүг бууруулж бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжинэ.

МАХН нь эх оронч үзэлтэй мянга мянган шударга иргэдийн ирүүлсэн экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэсэн, улс эх орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй шийдвэртэй алхмуудыг санал болгож байна.

Хөтөлбөрийн хүрээнд ИРГЭН -НОГООН СОЁЛ ИРГЭНШИЛ дэд хэсэгт экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн асуудлаас бүрдсэн хоорондоо харилцан хамааралтай хүн төвтэй хөгжлийн бодлогыг бий болгоно.

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл хотод амьдран, сурч боловсрох эрхтэй.

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг зогсоох,
- 0-5 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ,
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”, “ЗӨВ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлнэ.


ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул аймаг орон нутагт амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

- Аймагийн төвд хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллана.

ГУРАВ. АЙМАГ, СУМЫН ХҮРЭЭНД:

- Ахмадуудыг төр засгийн байгууллагад сайн дурын зөвлөхөөр авч ажилуулж, ахмад мэргэжилтнүүдийг зохих урамшуулалтайгаар ажиллуулсан ААН-үүдийг татварын тогтолцоогоор урамшуулах
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх,
- Аймагт хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлэх,
- Алслагдсан бэлчээрийг худаг усаар хангахад дэмжлэг үзүүлэх,
- “Эрүүл зөв амьдрал”, “Зөв хүнс” хөтөлбөрийг нэн тэргүүнд цэцэрлэг, сургууль, олон нийтийн үйлчилгээний газруудад хэрэгжүүлэх



ДОРНОД АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ

